



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 07 өдөр

Дугаар А/106

Есонбулаг

Үнэлгээний хороо байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь заалт, 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэг, 50.1.1 дахь заалт, 50 дугаар зүйлийн 50.4, 50.5 дахь хэсгүүд, Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн "Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, урамшууллын журам" А/254 дүгээр тушаалын хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгууллагын урсгал төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх Говь-Алтай аймгийн 7 дугаар цэцэрлэгийн 2024 онд хоол хүнс үйлдвэрлэлийн хүнсний бүтээгдэхүүн худалдан авах ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга	Э.Энхболд	(Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга)
	Ё.Нарангарав	(Хөндлөнгийн төлөөлөл) (Тохиролцсон)
Нарийн бичиг:	Б.Эрхбаяр	(Худалдан авах ажиллагааны газрын мэргэжилтэн)

2. Тендерийн баримт бичгийг боловсруулан гаргаж, худалдан авах ажиллагааг хугацаа алдалгүй чанартай зохион байгуулан, дүнг хуулийн хугацаанд танилцуулахыг Үнэлгээний хороо (Э.Энхболд)-нд үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ

C:\My document ZAX A-4

8200010505